

# СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.09 №04 (04)

ҮЙЛ ЯВДАЛ

## БҮХ ЦЭРГИЙН ИХ ХАР СҮЛДИЙГ ЦАГААЛАХ ТАЙЛГА БОЛОВ



Бүх цэргийн Их Хар сүлдийг цагаалах тайлга хаврын тэргүүн сарын шинийн зургаан улаан бич өдөр болох байсан ч цар тахлын улмаас хойшлогдож, энэ сарын 7-ны өдөр боллоо. Цагаалах тайлгад БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд, төрлийн цэргүүдийн командлагч нар, ХХЕГ,

Дотоодын цэргийн удирдлагууд оролцлоо. Тайлгын эхэнд Бүх цэргийн Их Хар сүлдний сүлдэч, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар Бүх цэргийн Их Хар сүлдийн "Заллагын өчил"-ийг дуудаж, хүрэлцэн ирсэн зочид хүндэтгэл үзүүлээ. Дараа нь Батлан хамгаалахын

сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг нар сүү, идээ шүүс зэргийг сүлдэндээ өргөж, адис авсан юм. Тэнгэрээс заяат Чингис хаан Бүх цэргийн Их Хар сүлдийг монголын ард олон, цэрэг эрсийн оюун санааг нэгтгэн, зориг хүчийг бадруулагч, хандсан зүгтээ

харгалдах дайсангүй болгогч шүтээн болгон тахиж, туг түмэн цэрэг, дайчин баатар эрсийнхээ манлайд залж явсны учир түүнийг өдгөө бид уламжлан авч, Монгол Улсын тусгаар тогтнолыг батлан хамгаалагч цэрэг эрсийн оройн дээд шүтээн Бүх цэргийн Их хар сүлд болгон залж байна.

## ТӨРЛИЙН ЦЭРГИЙН УДИРДЛАГУУДАЙ УУЛЗЛАА



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр ЗХЖШ болон төрлийн цэргийн удирдлагуудыг хүлээн авч уулзлаа. Тодруулбал, ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Батлан хамгаалахын сайдын зөвлөх

Ц.Дашзэвэг, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, хурандаа Ц.Жавхланбаатар, СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, Хуурай замын цэргийн командлагч, бригадын генерал Б.Амгаланбаатар, Агаарын цэргийн командлагч,

бригадын генерал О.Энхбаяр, Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Б.Баатар, Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, хурандаа Д.Баасандамба, Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга, хошууч Д.Жаргалсайхан нарын удирдлагын бүрэлдэхүүнтэй уулзсан юм. Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "ЗХЖШ-ын удирдлагад шинээр томилогдсон болон шинэ бүтцэд орж байгуулагдсан газрын дарга, бие бүрэлдэхүүнтэй ажил хэргийн уулзалт хийе гэж эртнээс төлөвлөсөн. Саяхан Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Тусгай хүчний болон Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч нар

томилогдон үүрэгт ажилдаа орлоо. Үүнтэй холбогдуулан энэхүү уулзалтыг энэ өдөр зохион байгуулж байна. Одоогийн нөхцөл байдалтай холбоотой товчхон бөгөөд тодорхой мэдээллүүдийг хийж, харилцан ярилцаж, санал солилцоно. Ажил хэрэгч уулзалт болно" гэж онцоллоо. Үүний дараа төрлийн цэргийн удирдлагууд тустусынкомандлал болон газрын зорилго, зорилт, үүрэг гүйцэтгэлт, өдөр тутмын үйл ажиллагаа, хэтийн төлөв, цаашид авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын талаар Батлан хамгаалахын сайдад танилцуулав. Төгсгөлд нь Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр уулзалтад оролцсон бүрэлдэхүүнд албан даалгавар, үүрэг чиглэл өгсөн юм.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРЛААР

## ӨНӨӨДРӨӨС ӨДӨРТ 15-20 МЯНГАН ХҮНИЙГ ДАРХЛААЖУУЛНА

Улсын онцгой комисс энэ сарын 8-ны өдөр хуралдаж коронавируст халдварын нөхцөл байдал, вакцинжуулалтын явц болон бусад асуудлыг хэлэлцэв. Хэдийгээр халдварын тоо нэмэгдэж байгаа ч иргэдийн амьдрал, аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг аль болох хэвийн үргэлжлүүлэхийг зорьж байна. Иймээс нийтийг хамарсан хөл хорио тогтоохгүй, шаардлагатай бол тухайн газарт хэсэгчилсэн байдлаар зохицуулна гэдгийг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга хэлэв. Цаашид хаа хаанаа

хариуцлагатай байж, халдвар хамгааллын дэглэмээ сахиж байхыг уриаллаа. Цаашид: - Тухай бүр нь зөвлөн туслаж байгаа ч халдвар хамгааллын дэглэм, тусгай шаардлага хангаагүй зарим аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоож, хариуцлага тооцох -Дархлаажуулалтыг эрчимжүүлэх -Олон нийтийг хамарсан урлагийн тоглолт, үзвэр, үйлчилгээний газруудын цагийн хуваарьт зохицуулалт хийх -Орон нутаг явж байгаа иргэдийг тухайн аймгийн Онцгой комисс халдварын нөхцөл байдал,

эрсдэлийн тооцоо, судалгаанд үндэслэж хүлээж авах эсэх шийдвэрээ гаргах зэргийг үүрэг, чиглэл болгов. Өнөөдөр 15.800 гаруй иргэнийг дархлаажуулалтад хамруулах болсон байна. **2021.03.09** -Улаанбаатар цахилгаан түгээх -Тохижилт үйлчилгээний компани -Цэвэрлэх байгууламж -Хил хамгаалах -Дотоод хэргийн их сургууль зэрэг байгууллага **2021.03.10**-наас -Худалдаа, үйлчилгээний салбар

**2021.03.11**-нээс -Боловсролын байгууллагын багш, ажилтан, алба хаагчдыг гэх мэтээр төлөвлөгөөний дагуу дархлаажуулна. Дүүрэг бүрт 10-15, хотын хэмжээнд 85 цэг ажиллах юм. Вакциныг төлөвлөсний дагуу татаж аван долоодугаар сард дархлаажуулж дуусахыг зорьж байна. Ирэх сар хүртэл болох байсан урлагийн 17 тоглолтын 90 гаруй хувь нь цуцлагдсан, 10 орчим хувь нь танхимын 50 хувийн дүүргэлттэй үйлчилж байна гэсэн судалгаа гарчээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
-5°C	-13°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
42°C	26°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
15°C	1°C

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,420.0	3,486.0
CNY	438.20	442.50
RUB	37.83	39.58
JPY	26.40	27.06
KRW	2.48	2.60

### КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	108
НИЙТ БҮРТГЭГДСЭН	3336
ЭДГЭРСЭН	2588
НАС БАРСАН	7

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	4
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	155
ЭДГЭРСЭН	833

### ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.09. /МЯГМАР ГАРАГ/

**ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН БАР САРЫН ГУРВАН ХӨХ УЛААН ЛУУ ӨДӨР**

**Үс засуулвал:**  
Жаргал үргэлжид ирнэ.

**Наран ургах, шингэх:**  
07.17-18.48

**Барилдлага:** Түлэх  
**Шүтэн барилдлага:** Төрөн түгэхүй  
**Суудал:** Ус

Аргын тооллын 3 сарын 9, Ангараг. Билгийн тооллын 26, Элдэв тэнгэртэн одтой, улаан луу өдөр. Өдрийн наран 7 цаг 17 минутад мандан, 18 цаг 48 минутад жаргана. Тухайн өдөр хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, лус тахиx, хур оруулах, зэтгэрийг номхтогх, хөгжмийн зэмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хул газар яваар одгосод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал жаргал үргэлжид ирэх сайн.

# ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 2021 ОНЫ “ХАТАН ИЖИЙ” НАР ТОДОРЛОО



Монгол Улсын Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд хөдөлмөр зүтгэл, оюун ухаан, чин сэтгэлээ зориулан хөдөлмөрлөхийн зэрэгцээ цэргийн ханийн үүрэг хүлээж, гэр бүл, үр хүүхдүүдээ ачлан тэтгэж, бат найдвартай ар тал нь болж, бахархан дуурайх амьдрал, ажил үйлсийн түүхэн замналыг бүтээж яваа эзхүүдээ алдаршуулах, тэдний гавьяаг түмэн олонд

түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн сайн сайхныг нийгэмд таниулах зорилго бүхий “Зэвсэгт хүчний Хатан ижий” ёслол хүндэтгэлийн арга хэмжээ энэ сарын 5-ны өдөр зохион байгуулагдаж, 9 Хатан ижийг өргөмжлөн, хүндэтгэл үзүүллээ.

2015 онд ЦДБЭЧ-аас анхлан санаачилж, БХЯ, ЗХЖШ-тай хамтран зохион байгуулж ирсэн, жилээс жилд өргөжин

тэлж буй “Хатан ижий”-гийн энэ жилийн сонгон шалгаруулалтад БХЯ-ны харьяа байгууллагууд болон Зэвсэгт хүчний анги, нэгтгэлүүдээс нийт 57 ээжийн тодорхойлолт, танилцуулга ирсэнээс Д.Норжин /УБХИС/, Д.Цэцэгээ /016/, Н.Алтанцэцэг /БХЯ-ны Ахмадын хороо/, Г.Янжмаа /120/, Г.Чулуунцэцэг /327/, Д.Энхтуяа /ЦДБЭЧ/, Э.Эрмаа /“Зэв” концерн/,

М.Энхтуяа /011/, А.Оюунгэрэл /150/ нарын 9 ээж шалгарч, “Өргөмжлөл” хүндэтгэлийн эздээр тодорсон юм.

Тэд 56-75 насны ээжүүд бөгөөд 4-6 хүүхэд төрүүлж, эрүүл саруул, эрдэм боловсролтой өсгөн, хүмүүжүүлсэн, өөрөө төдийгүй хань, үр хүүхдүүд нь Зэвсэгт хүчинд алба хаадаг, Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд амжилттай оролцон, үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн зэрэг амжилтууд, бахархам амьдралын эзэд юм. Тухайлбал, хатан ижий Г.Янжмаа дөрвөн хүүхэд төрүүлж өсгөсөн бөгөөд тэдний гэр бүлээс өөрөө, хань, хүүхдүүд, хүргэн, бэр гээд 10 хүн Зэвсэгт хүчинд алба хаадаг аж.

Мөн хатан ижий М.Энхтуяа хантайгаа Зэвсэгт хүчинд амьдралаа зориулсан төдийгүй төрүүлж, өсгөсөн дөрвөн хүүхдээс хоёр хүү нь Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд 2-4 удаа үүргээ амжилттай гүйцэтгэсэн байна.

Зургаа дахь жилдээ уламжлал болон зохион байгуулагдсан энэхүү ёслол хүндэтгэлийн ажиллагааны өмнөх жилүүдэд шалгарсан “Хатан ижий” өргөмжлөлт 46 ээж сайн дураар эвлэлдэн нэгдэж, “Зэвсэгт хүчний Хатан ижий” төрийн бус байгууллага байгуулсан бөгөөд тэргүүнээр нь 2017 оны хатан ижий Ц.Цэцэгээ ажилладаг ажээ.

Зэвсэгт хүчний хатан ижий нараас хамгийн өндөр настай нь өдгөө 96 настай Р.Рэнчинцоо гуай /167/ бөгөөд Өмнөговь аймагтаа амьдран суугаа. Хатан ижий Ө.Марууш гуай /350/ хамгийн олон хүүхэдтэй нь буюу 14 хүүхэд төрүүлж өсгөсөн агаад төрийн цэргийн байгууллагад энэ гэр бүлээс 13 хүн алба хаадаг. Хамгийн залуу хатан ижий Б.Эрдэнэчимэг /120/ 52 настай, 5 хүүхэд төрүүлж өсгөсөн, Зэвсэгт хүчинд зургаан хүн алба хаадаг ажээ.

Хатан ижий нар энэ багагүй хугацаанд Төрийн цэргийн байгууллагын эмэгтэй цэргийн алба хаагчдын чуулганд уригдан оролцож, ОХУ-ын Улаан-Үүд хотын түүхэн дурсгалт газрууд болон Итгэлт хамбын аялал, Цонжин болдог дахь Чингисийн хөшөө, Манзуширын хийд, Гүнжийн сүм, Өүлэн эхийн хөшөөт цогцолбор болон Горхи-Тэрэлжийн үзэсгэлэнт байгалийн цогцолбор газруудаар тойрон аялал зохион байгуулж, хатан ижий нартаа болон нийгэмд чиглэсэн олон төрлийн ажлыг зохион байгуулжээ.

Мөн энэ жил “Хатан ижий” хүндэт тэмдгийг “Хас гоёл” компаниар хийлгэж, хатан ижий нарынхаа намтрын товчоон бүхий шинэхэн номыг хэвлүүлэн, дээжийг нь энэ онд шалгарсан хатан ижий нартаа гардуулан өгсөн юм.

## ХИЛИЙН ЧАНАДААС

### ЦЭРГИЙН БАГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ

БНӨСУ-д явагдаж байгаа энхийг сахиулах ажиллагааны Жуба бүсийн командлагч, хурандаа Б.Эрдэнэбат болон штабын дарга, хүний нөөц, ар тал хариуцсан офицер болох Австрали, Бангладеш зэрэг улсын албаны хүмүүс 2 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд ажиллагааны газар оронд үүрэг гүйцэтгэж буй өөрийн харьяаны анги, салбаруудын үйл ажиллагаатай биечлэн танилцлаа.

Энэ үеэр тэд коронавирусын хязгаарлалтын дэглэм барьж зарим анги, салбарууд, БНХАУ, Руанда улсын мотобуудлагын батальонууд, Балба улсын тусгай мотобуудлагын рот, Руанда



улсын нисэх хүчний скадрил, Бангладеш улсын усан цэргийн рот, Тайландын инженерийн рот, Балба улсын агаарын түргэн

байрлах ротын үйл ажиллагаатай танилцсан юм.

Хошууч Н.ГАНТУЛГА

## ЦАХИМ ШУУДАНД

### ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА ХААГЧДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын албанаас төрийн цэргийн байгууллагуудад сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулахаар “Батлан хамгаалахын хяналт, шалгалтын 2021 оны нэгдсэн төлөвлөгөө”-нд тусган ажиллаж байна. Уг ажлын хүрээнд энэ сарын 5-ны өдөр

Ажлын албаны дарга, хурандаа Т.Мөнхбаяр, мэргэжилтэн, хошууч А.Октябрь нар “Батлан хамгаалах хууль, тогтоомж, цэргийн алба хаагчийн ёс зүй” гэсэн сэдвээр Нийслэлийн онцгой байдлын газар, Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв, Аврах ангийн 50 гаруй алба хаагчдад сургалт зохион байгууллаа.

## ДЭЛХИЙН ХҮН АМЫН 75 ХУВИЙГ ДАРХЛААЖУУЛАХАД ДӨРВӨН ЖИЛ ШААРДЛАГАТАЙ



Дэлхийд хоногт дунджаар 7 сая 650 гаруй мянган хүн д а р х л а а ж у л л а т а д хамрагдаж байна. Энэ хурдаар явбал хоёр тунт вакцинаар дэлхийн нийт хүн амын 75%-ийг дархлаажуулахад дөрвөн жил шаардлагатай тооцоо гарчээ.100 хүн тутамд 95.4 тун вакцин зарцуулсан үзүүлэлтээрээ Израил Улс

дэлхийд тэргүүлж байна. Энэ сарын 07-ны байдлаар 111 оронд 300 орчим сая тун вакцинаар дархлаажуулалт хийжээ. COVAX хөтөлбөрийн хүрээнд БНЭУ-ын Serum хүрээлэнд үйлдвэрлэсэн “AstraZeneca” компанийн хөгжүүлсэн CO-VISHIELD вакциныг түгээх эхний шатны хуваарийг энэ сарын 2-ны өдөр шинэчлэн танилцуулсан байна.

Хуваарийн дагуу ирэх 5 дугаар сарыг дуустал хөтөлбөрт оролцогч 142 улсад 237 сая тун вакцин нийлүүлэх юм. Түгээж эхэлснээс хойш эхний 12 хоногт Африк, Ойрхи Дорнод, Ази, Номхон далайн болон Латин Америкийн 28 улсад 15.7 сая орчим тун вакцин хүргүүлсэн бөгөөд энэ сарын 8-14 хүртэлх дараагийн 7 хоногт 31 орон 14.4 сая тун вакцин хүлээн авах юм байна.

### 2021 ОНЫ 3 ДУГААР САРЫН 7-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР ХҮН АМАА ДАРХЛААЖУУЛЖ БАЙГАА ТЭРГҮҮЛЭХ 10 ОРОН:

Улс	Хамрагдсан хүн (сая)	Вакцины төрөл
1. АНУ	87.9	Pfizer Moderna Johnson&Johnson
2. БНХАУ	52.5	Sinopharm/Beijing Sinovac Can-sino Sinopharm/Wuhan
3. Британи	22.8	Pfizer Moderna AstraZeneca
4. Энэтхэг	20.6	Bharat AstraZeneca
5. Бразил	10.3	Sinovac AstraZeneca
6. Турк	9.9	Sinovac
7. Израил	8.6	Pfizer Moderna
8. ОХУ	7.5	Sputnik V
9. ХБНГУ	7.3.	Pfizer Moderna AstraZeneca
10. Эмират	6.2	Pfizer Gamaleya Sinopharm/Beijing

**СОЁМБО СОНИН**  
“Соёмбо” сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХУЯГ

Эхийг “Соёмбо”  
сонини редакцал  
бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл бодол сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018  
И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029